

Олон улсын сэтгүүлчдийн холбоо (ОУСХ)-ны 2019-2022 оны

Үндсэн дүрэм

ОУСХ-ны Дэлхийн Бүх гишүүдийн хурлаар 2019 оны зургадугаар сард Тунис улсын Тунис хотноо батлав.

Тунисийн Бүх гишүүдийн хурлаас баталсан өөрчлөлтийг Italic Bold тэмдэглэгээгээр хийв:

Бүлэг I: Байгууллагын нэршил ба төв байр

1. Энэ байгууллагын албан ёсны нэр нь Олон улсын сэтгүүлчдийн холбоо. Төв байр нь тус Үндсэн дүрэм батлагдах үед Бельги улсын Брюссель хотын Олон улсын хэвлэлийн төвийн Residence ордны С байр, Rue de la Loi 155-ын 1040 хаягт байрлаж байв.

Бүлэг II: Байгууллагын шинж чанар

2. а) Олон улсын сэтгүүлчдийн холбоо (*цаашид Холбоо гэх. Орч.*) нь сэтгүүлчдийн үйлдвэрчний эвлэлүүдийн эвсэл холбоо юм. Тус Холбоо нь үйлдвэрчний эвлэл, сэтгүүлзүйн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал шийдвэрлэх зорилготой бөгөөд олон ургальч ардчилал, хүний үндсэн эрх, эрх чөлөөг дэмжих хүрээнд үүсгэн байгуулагдсан. ОУСХ нь үзэл суртал, улс төр, төр засаг болон шашины аливаа байгууллагаас хараат бус байна. Холбоо нь өөрийн гишүүн байгууллагуудаа төлөөлөх, тэдэнд хөдөлмөрлөх үндсэн эрхийг хамгаалах болон мэргэжлийн бүхий л асуудлаарх мэдлэг боловсрол олгох, судалгаа шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлдэг. ОУСХ нь тив, бүсийн эвсэл холбоодоос бүрдсэн өөрийн гишүүн байгууллагуудаа дэмжин хамгаална.

б) Олон улсын сэтгүүлчдийн холбоо нь Бельги улсын хууль тогтоомжид тодорхойлсноор **Association Internationale Sans But Lucratif** (AiSBL буюу *ашгийн төлөө бус холбоо. Орч.*) юм. AiSBL болохын хувьд хүлээсэн Холбооны үүрэг хариуцлагыг Захиргааны хороо хэрэгжүүлнэ.

Бүлэг III: Зорилго, зорилт

3. Холбоо нь дараахь зорилго, зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

(а) Сэтгүүлчдийн эрх, эрх чөлөөг хамгаалан бэхжүүлэх;

(б) Сэтгүүлчдийн эрхийн зөрчилд судалгаа, хяналт шинжилгээ хийх, тэднийг болон тэдний эрхэлж буй үйл ажиллагааг хамгаалах замаар мэдээллийн эрх чөлөө,

хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлзүйн хараат бус байдлыг хөхиүлэн дэмжиж, сахин хамгаалах;

(c) Сэтгүүлзүйн мэргэжлийн ур чадварыг дэмжих, чанаржуулах, мөн түүнчлэн сэтгүүлзүйн болон сэтгүүлзүйн боловсролын дээд хэмжүүрийг сайшаан дэмжих;

(d) Нийт сэтгүүлчдийн нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг сайжруулах, гишүүн эвлэл холбоодыг хамтын хэлэлцээрээр дэмжин хамгаалах;

(e) Тив, бүс нутгийн эвсэлүүдийг нэгтгэх замаар гишүүн эвлэл холбоодын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, үйлдвэрчний эвлэлийн хөгжлийг дэмжих;

(f) Редакцийн ардчиллыг дэмжин сахих;

(g) Сэтгүүлчдийн болон мэргэжлийн сэтгүүлзүйн нийгэм дэх үүрэг, нэн ялангуяа ардчилал, эрх чөлөөнд тэдгээрийн оруулах хувь нэмрийг хөхиүлэн дэмжих;

(h) Сэтгүүлчдэд зориулсан мэргэжлийн болоод үйлдвэрчний эвлэлийн боловсрол, сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

(i) Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохицуулах, гишүүн эвлэл холбоод ба ажил олгогч байгууллагуудын хоорондын хамтын гэрээнд сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаарх сургалт тусгуулах;

(j) Гишүүн эвлэл холбоодод өөрсдийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бусад гишүүн эвлэл холбоодын гишүүдэд сайн санааны дэмжлэг тусалцаа үзүүлэхийг сайшаан дэмжих;

(k) Эдгээр зорилгыг хэрэгжүүлэх үүднээс олон улсын, засгийн газрын болон төрийн бус холбогдох байгууллагуудтай нягт харилцаа холбоо тогтоон хөгжүүлэх;

(l) Зохиогчийн эрхийг хамгаалах, олон улсын нөхөн олговрын тогтолцооны төлөө хүчин зүтгэх,

(m) Сэтгүүлзүй дэх тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, гишүүн эвлэл холбоодыг уг зорилтыг хэрэгжүүлэхийг сайшаан дэмжих;

(n) Үзэн ядалтын үг хэллэгийн эсрэг тэмцэх;

(o) Сэтгүүлзүйн эх сурвалж хамгаалахын төлөө хүчин зүтгэх, засгийн газар, хувийн хэвшлүүдийн зүгээс бүхий л төрлийн өгөгдөл мэдээлэл хадгалахын эсрэг тэмцэх.

Бүлэг IV: Гишүүнчлэл

4. Холбоо нь түүний шинж чанар, зорилгод нийцсэн дүрэм, үйл ажиллагаа бүхий, мөн доор тодорхойлсон үндэсний эвлэл холбоодод бүрэн гишүүнчлэл олгоно. Үүнд:

(а) Сэтгүүлчдийн үйлдвэрчний эвлэл холбоо, тухайлбал, сэтгүүлчдийн мэргэжлийн, ёс зүйн, ёс суртахууны болон материаллаг эрхийг, нэн ялангуяа хамтын хэлэлцээрийн дагуу сахин хамгаалах, бэхжүүлэх тэргүүлэх чиг үүрэг бүхий төлөөлөх, ардчилсан байгууллага байна. Үүнийг тодруулахад, сэтгүүлч гэж ажлын ихэнх цагаа сэтгүүлзүйн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд зориулж, орлогынхоо ихэнх хувийг уг үйл ажиллагаанаас олдог ажил эрхлэгч буюу чөлөөт сэтгүүлчийг хэлнэ.

(b) Хэвлэл мэдээлийн эрх чөлөөг хангахад чиглэсэн, тухайлбал энэ эрх чөлөө нь НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, хэвлэл мэдээллийн бүхий л төрлөөр мэдээлэл цуглуулах, түгээх эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх, санаа бодлоо хуваалцах эрх чөлөө, түүн дотроо засгийн газар, улс төр болоод олон нийтийн, хувийн аль аль байгууллагуудыг шүүмжлэх, сөрөх эрх чөлөөнд нийцсэн байх.

5. Холбооны гишүүнчлэл нь ажил олгогч бүхий сэтгүүлчдийн эвлэл, мэргэжлийн тодорхой салбарт ажилладаг үйлдвэрчний бус байгууллагуудад нээлттэй биш.

6. Холбооны гишүүнээр элсэх эвлэл холбоо нь үйлдвэрлэлийн салбарт түшиглэсэн бол түүний гишүүнчлэлийг сэтгүүлч гишүүдийн тооноос шалтгаалан хүлээн зөвшөөрч болно.

7. 4(a) хэсэгт заасанчлан үндэсний сэтгүүлчдийн байгууллага нь сэтгүүлчдийн эвлэл холбоо биш боловч 4(b) хэсэгт тодорхойлсноор хэвлэлийн эрх чөлөөний төлөө ажилладаг бол хамтрагч гишүүнээр элсүүлж болно.

8. Тус Үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол хамтрагч гишүүд Холбооны бүхий л үйл ажиллагаанд оролцож болно. Эдгээр гишүүд нь Бүх гишүүдийн хуралд нэг төлөөлөлтэй байх боловч санал өгөх, түүнчлэн Холбооны ажлын албанд нэр дэвших, дэвшүүлэх эрхгүй. Хамтрагч гишүүд нь Холбооны дэмжлэгтэйгээр бүрэн гишүүнчлэлийн нөхцөл шаардлагад нийцэхийн төлөө хүчин чармайлт гаргах ба шаардлагад нийцсэн тохиолдолд бүрэн эрхт гишүүнээр элсэх хүсэлт гаргаж болно. Уг нэмэлт өөрчлөлт хийгдсэн өдрөөс 3 жилийн дотор бүрэн эрхт гишүүнээр элсэх хүсэлт гаргаагүй аливаа хамтрагч гишүүний талаар ОУСХ-ны Гүйцэтгэх хороонд мэдэгдэж, цаашид гишүүнээр үлдэх эсэхийг хэлэлцэнэ.

9. Гишүүн эвлэл холбоод нь Холбооны бүх бичиг баримтад нэвтрэх, хүссэн цагтаа бүхий л төрлийн мэдээлэл авах эрхтэй. Үүнд хувийн эмзэг өгөгдөл мэдээлэл хамаарахгүй.

Бүлэг V: Гишүүнээр элсэх өргөдөл

10. Холбоонд гишүүнээр элсэх өргөдлийг Ерөнхий нарийн бичгийн даргад зааврын дагуу гаргах ба өргөдөл гаргагч нь байгууллагынхаа үндсэн дүрмийг хавсаргана. Ерөнхий нарийн бичгийн дарга гишүүнчлэл хүссэн өргөдөл бүрийг бүх гишүүн эвлэл холбоодод мэдээлнэ.

11. Гүйцэтгэх хороо нь өргөдөл тус бүрийг авч хэлэлцэнэ. Тус хороо нь санал хураалтаар гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар өргөдөл гаргагчийг бүрэн эрхт буюу хамтрагч гишүүнээр элсүүлнэ. Гүйцэтгэх хороо нь өргөдлийг татгалзах эсвэл дараагийн хурлаар авч хэлэлцэхээр хойшлуулж болно.

12. Татгалзсан хариу авсан өргөдөл гаргагч нь ээлжит Бүх гишүүдийн хуралд Гүйцэтгэх хорооны тухайн шийдвэрийн эсрэг гомдол гаргаж болно. Гүйцэтгэх хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй ямар ч гурван гишүүн эвлэл холбоо нь уг шийдвэрийн эсрэг ээлжит Бүх гишүүдийн хуралд гомдол мэдүүлж болно. Аль ч тохиолдолд эдгээр гомдлыг Ерөнхий нарийн бичгийн даргад шийдвэрийг мэдэгдсэнээс хойш гурван сарын дотор бичгээр гаргана.

13. Хамтрагч гишүүний статусыг бүрэн гишүүнчлэлээр өөрчлөх горим өмнөх хэсэгт заасантай ижил байна.

14. Амжилттай шалгарсан өргөдөл гаргагч гишүүнээр элссэн тухайн жилийн хураамжаа төлснөөр ОУСХ-ны гишүүнчлэл нь баталгаажна. Эвлэл холбоод гишүүнээр элссэн өдрөөс хойших тухайн жилийн үлдэгдэл хураамж төлнө.

Бүлэг VI: Гишүүнчлэлээс хасах, чөлөөлөх

15. Гишүүн эвлэл холбоог Бүх гишүүдийн хурлын шийдвэрээр дараахь тохиолдолд гишүүнчлэлээс хасна. Үүнд:

(a) Энэ үндсэн дүрмийн 4 дүгээр бүлэгт заасан гишүүнчлэлийн нөхцөл шаардлагыг хангаагүй бол, эсвэл

(b) Зорилго болон зарчимтай зөрчилдөх буюу Холбооны ашиг сонирхолд харшлах үйлдэл гаргасан, эсвэл

(c) Гишүүнчлэлийн хураамжаа төлөх ёстой хугацаанаас 12 сараар хэтрүүлсэн бол.

Гишүүнчлэлийн хураамжаа төлөөгүйн улмаас Бүх гишүүдийн хурлын шийдвэрээр гишүүнчлэлийг нь түдгэлзүүлсэн аливаа гишүүн эвлэл холбоог тухайн шийдвэр гарсан өдөр хүртэл хуримтлагдсан өрөө барагдуулахыг зөвшөөрсөн тохиолдолд гишүүнчлэлийг сэргээнэ.

16. Гүйцэтгэх хороо нь нөхцөл байдлыг сайтар нягтлан судалсны үндсэн дээр, хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар гишүүнчлэлээс түдгэлзүүлэх түр шийдвэр гаргана. Аливаа шийдвэр гарсан даруйд тухайн гишүүнд мэдэгдэнэ. Гишүүн нь дараагийн Бүх гишүүдийн хуралд уг шийдвэрийн эсрэг гомдол гаргаж болно. Бүх гишүүдийн хурлаар шийдвэрийг баталгаажуулах эсвэл няцааж болох боловч тэр хүртэл тухайн гишүүн гишүүнчлэлээс түдгэлзсэн хэвээр байна.

Гишүүн эвлэл холбоог гишүүнчлэлээс түдгэлзүүлэх түр шийдвэрийг 4 дүгээр бүлгийн 15 (с) заалтын дагуу гаргасан бол ОУСХ-ны Гүйцэтгэх хороо гишүүнээс түдгэлзүүлсэн эвлэл холбоодыг өр барагдуулсан эсвэл гишүүнчлэлийн хураамж бүрэн төлсөн тохиолдолд гишүүнчлэлээс түдгэлзүүлсэн шийдвэрийг цуцална.

17. Аливаа гишүүн нь Ерөнхий нарийн бичгийн даргад зургаан сарын өмнөөс мэдэгдэл бичгээр гарган, холбооны гишүүнээс чөлөөлөгдөж болно.

Бүлэг VII: Бүх гишүүдийн хурал

18. Бүх гишүүдийн хурал нь Холбооны удирдах дээд байгууллага мөн.

19. Бүх гишүүдийн хурал бүрэн эрхт гишүүн эвлэл холбоо болон хамтрагч гишүүдийн төлөөллөөс бүрдэнэ. Бүрэн эрхт гишүүд нь үндэсний хэмжээнд төлөөлөгчид томилох эрхтэй ба Бүх гишүүдийн хуралд эзлэх саналын тоо дараахь шатлалтай байна. Үүнд:

100 хүртэлх гишүүд 1 төлөөлөгч/санал

600 хүртэлх гишүүд 2 төлөөлөгч/санал

1.200 хүртэлх гишүүд 3 төлөөлөгч/санал

2.400 хүртэлх гишүүд 4 төлөөлөгч/санал

4.800 хүртэлх гишүүд 5 төлөөлөгч/санал

8.000 хүртэлх гишүүд 6 төлөөлөгч/санал

12.000 хүртэлх гишүүд 7 төлөөлөгч/санал

15.000 хүртэлх гишүүд 8 төлөөлөгч/санал

26.000 хүртэлх гишүүд 9 төлөөлөгч/санал

26.000-аас дээш гишүүд 10 төлөөлөгч/санал.

б) Төлөөлөгчдийн жөндөрийн тэгш байдал: Гишүүн эвлэл холбоод нь эмэгтэй, эрэгтэй төлөөлөгчдийн тоог эвлэл холбооны гишүүнчлэлийн ноогдол хувьтай дор

хаяж тэнцүү харьцаатай байхад анхаарна. Гэсэн хэдий ч гурваас дээш төлөөлөгчөөс бүрдсэн төлөөлөл бүрт нэг эрэгтэй, нэг эмэгтэй төлөөлөгч, харин таван төлөөлөгчөөс дээш байвал 2 эрэгтэй, 2 эмэгтэй төлөөлөгч оруулахыг зорино.

20. Бүх гишүүдийн хурал ердийн үед гурван жил тутам хуралдана. Гүйцэтгэх хороо нь гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар аль ч үед Бүх гишүүдийн онцгой хурал зарлаж болно. Холбооны бүрэн эрхт гишүүдийн тал хувь нь бичгээр шаардсан тохиолдолд Гүйцэтгэх хорооноос Бүх гишүүдийн онцгой хурал зарлана.

21. Ердийн Бүх гишүүдийн хурал болох газар, огноог гишүүн эвлэл холбоодод 8 сараас багагүй хугацааны өмнө мэдээлнэ. Урилга болон урьдчилсан хөтөлбөрийг гишүүдэд зургаан сараас багагүй хугацааны өмнө илгээх бөгөөд ажлын баримт бичгийг Бүх гишүүдийн хурал эхлэхээс нэг сараас багагүй хугацааны өмнө илгээнэ.

22. Уг Үндсэн дүрэмд өөрөөр заагаагүй бол гишүүн эвлэл холбоод, Гүйцэтгэх хороо болон ОУСХ-ны бүсийн байгууллагууд саналаа Бүх гишүүдийн хурал эхлэхээс таван сараас багагүй хугацааны өмнө Ерөнхий нарийн бичгийн даргад илгээнэ.

Уг Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах аль эсвэл Холбоог татан буулгах саналыг 9 дүгээр бүлэгт заасан горимын дагуу явуулна. Хугацаанаас хоцорсон саналыг санал хураалтад оролцогч төлөөлөгчдийн дийлэнх хувь зөвшөөрсөн тохиолдолд Бүх гишүүдийн хурлаар авч хэлэлцэнэ.

23. Бүх гишүүдийн онцгой хурлын талаар гишүүн эвлэл холбоодод тухайн хурал эхлэхээс зургаан долоо хоногоос багагүй хугацааны өмнө мэдэгдэнэ.

24. Ээлжит Бүх гишүүдийн хурлаар дараахь асуудлыг шийднэ. Үүнд:

(а) Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгчдийг сонгох;

(b) Гүйцэтгэх хорооны зөвлөмжийн дагуу Бүх гишүүдийн хурлын үйл ажиллагааны журам, түүн дотроо итгэмжлэгдсэн хүнээр дамжуулан өгөх санал хуваарилах зэргийг баталж, кворум ирц тогтоох;

(c) Бүх гишүүдийн хурлыг үр дүнтэй явуулахад шаардлагатай Бүх гишүүдийн хурлын комисс, ажлын хэсэг байгуулах, журам тогтоож, төлөөлөгчдийн оролцоог хангахад чиглэх;

(d) Гүйцэтгэх хорооны нэрийн өмнөөс өгч буй Ерөнхий нарийн бичгийн дарга болон Холбооны санхүүгийн асуудал хариуцсан даргын тайланг хүлээн авч, хэлэлцэх, санал хураах;

(e) Гишүүнчлэлийн асуудлаарх санал гомдлыг шийдвэрлэх;

(f) Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал авч хэлэлцэх;

(g) Бүх гишүүдийн хурлын ирэх гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэх санхүүгийн стратеги тодорхойлох;

(h) Бүх гишүүдийн хурлын ирэх гурван жилийн хугацаанд мөрдөх бүрэн эрхт болон хамтрагч гишүүнчлэлийн хураамж тогтоох;

(i) Ирэх гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах;

(j) Гишүүн эвлэл холбоодын зүгээс хэлэлцэх асуудалд ирүүлсэн саналыг хэлэлцэх;

(k) Холбооны ажилтнууд болон Гүйцэтгэх хорооны бусад гишүүдийг 8 дугаар бүлэгт заасны дагуу сонгох;

25. Бүх гишүүдийн хурал гуравны хоёр хувийн санал шаардаагүйгээс бусад тохиолдолд дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргана.

(a) Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг батлах;

(b) Санхүүгийн стратеги тодорхойлох;

(c) Гишүүнчлэлийн татвар тогтоох.

Холбоог татан буулгах тухай өргөдлийг гагцхүү гуравны хоёрын саналаар авч хэлэлцэнэ. Холбоог татан буулгах талаар санал хураах кворум ирц нь Бүх гишүүдийн хуралд төлөөлөх саналын 50%-иас доошгүй хувь байна.

26. Бүх гишүүдийн хурлын бүх төрлийн сонгуулийн саналыг нууцаар хураах ба үүнийг Бүх гишүүдийн хурлын тэргүүлэгчид үйл ажиллагааны журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

Бүлэг VIII: Гүйцэтгэх хороо, Удирдах гишүүд ба Захиргааны хороо

27. Гүйцэтгэх хороо нь Бүх гишүүдийн хоёр хурлын хоорондох хугацаанд Холбооны удирдах дээд байгууллага байна. Тус Хороо удирдах гишүүд болон бусад 16 гишүүдээс бүрдэх ба эдгээр гишүүдийг Бүх гишүүдийн хурлаар

дараагийн Бүх гишүүдийн хурлын хаалт хүртэл хугацаагаар сонгоно. Тус Хороо жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Хорооноос гаргасан аливаа шийдвэр нь санал өгөх эрхтэй 11-ээс доошгүй гишүүдийн кворум ирцээр баталгаажна. Хороо нь үндсэн дүрмийн хүрээнд өөрийн үйл ажиллагааны журам, горимыг тогтооно. Гүйцэтгэх хороо нь Гүйцэтгэх хороо болон Бүх гишүүдийн хурлаас гарсан шийдвэрүүдийн бүртгэлийг Холбооны төв байранд байлгах асуудлыг хариуцна.

28. Гүйцэтгэх хороо нь Холбооны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг Бүх гишүүдийн хурлын шийдвэрт нийцүүлэх ажлыг хариуцаж, Бүх гишүүдийн хуралд ажлаа тайлагнана. Гүйцэтгэх хороо нь хурлын үеэр мөрдөх үйл ажиллагааны журам болон кворум ирц тогтоож, шаардлагатай тохиолдолд хуралд оролцох боломжгүй гишүүдэд итгэмжлэгдсэн хүнээр дамжуулан өгөх саналыг хуваарилах горим тогтооно.

29. Гүйцэтгэх хорооны жил бүрийн анхны хурал нь аудитын дүгнэлт баталгаажуулах, төсөв батлах жилийн ерөнхий хурал байна. Гишүүдэд хурал товлосон өдрийг дор хаяж дөрвөн сарын хугацааны өмнө урьдчилан мэдэгдэнэ. Өргүй гишүүд дор хаяж хоёр сарын өмнөөс хүсэлт гаргаж, ажиглагч явуулах эрхтэй. Тухайн хурлын тэмдэглэлийг бүх гишүүн эвлэл холбоодод илгээнэ. Гүйцэтгэх хорооноос Холбооны дотоод журам, түүний дотор удирдах гишүүд, ажилтнуудын дагаж мөрдөх дэг журам, Холбооны хэм хэмжээг тогтооно. Эдгээр дүрэм журам нь бүх гишүүн эвлэл холбоодод нээлттэй байна.

30. Холбооны удирдах гишүүд нь ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгч, хоёр дэд ерөнхийлөгч болон санхүүгийн даргаас бүрдэнэ. Удирдах гишүүдийг Бүх гишүүдийн хурлаар бүрэн эрхт гишүүн эвлэл холбоод нэр дэвшүүлэн сонгоно. Нэр дэвшигчид нь өөрсдийн эвлэл холбоодын төлөөллийн бүрэлдэхүүнд багтсан байна. Гишүүн эвлэл холбоо, улс орон тус бүр нэгээс илүү удирдах гишүүн сонгохгүй. Бүх гишүүдийн хурлаар нэг эрэгтэй, нэг эмэгтэйг дэд ерөнхийлөгчөөр сонгоно.

31. Удирдах гишүүдээс гадна, Бүх гишүүдийн хурлаар Гүйцэтгэх хорооны 16 гишүүнийг дараахь нөхцөлөөр сонгоно. Үүнд:

(a) Бүрэн эрхт гишүүн эвлэл холбоод тус хорооны гишүүнд нэр дэвшүүлж болох бөгөөд нэр дэвшигчид өөрсдийн эвлэл холбоодын төлөөллийн бүрэлдэхүүнд багтсан байна;

(b) Европ, Ази, Африк болон Латин Америкийн бүс нутаг бүрээс хоёроос доошгүй гишүүнийг сонгоно. Мөн Хойт Америк болон Номхон далайн арлын бүс нутаг бүрээс нэгээс доошгүй гишүүнийг сонгоно;

(с) Аливаа гишүүн эвлэл холбоо, улс орон тус бүрээс нэгээс илүү гишүүн сонгохгүй.

32. Бүх гишүүдийн хурлаар бүс нутаг тус бүрээс хоёр нөөц гишүүн болон ямар нэгэн бүс нутгийн шаардлага тогтоохгүйгээр хоёр ерөнхий нөөц гишүүн сонгоно. Тухайн сонголт бүрээс хамгийн их санал авсан нөөц гишүүн нь тэргүүн нөөц гишүүнд тооцогдоно. Гишүүн нь Гүйцэтгэх хорооны хуралд оролцох боломжгүй бол хурал болохоос дор хаяж дөрвөн долоо хоногийн өмнө Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга дараахь эрэмбээр тохирох нөөц гишүүнийг хуралд оролцохыг мэдэгдэнэ. Үүнд: бүс нутгийн тэргүүн нөөц гишүүн, бүс нутгийн удаахь нөөц гишүүн, ерөнхий тэргүүн нөөц гишүүн, ерөнхий удаахь нөөц гишүүн. Ийм тохиолдолд нөөц гишүүн Гүйцэтгэх хорооны гишүүний адил бүх эрх, үүрэг болон эрх мэдэл эдэлнэ.

33. Гүйцэтгэх хорооны аливаа удирдах гишүүн буюу гишүүн нь сонгогдсоноос хойш

(a) нас барах; эсвэл

(b) Гүйцэтгэх хорооноос чөлөөлөгдөх; эсвэл

(c) Гүйцэтгэх хорооны гишүүдийн тавны дөрвийн гаргасан саналаар тус Үндсэн дүрмийн дагуу тус хорооны гишүүний бүрэн эрх дуусгавар болно.

Журам 28-д заасны дагуу Гүйцэтгэх хорооны гишүүнд тохирох нөөц гишүүнийг дараахь эрэмбээр шалгаруулна. Үүнд: бүс нутгийн тэргүүн нөөц, бүс нутгийн удаахь нөөц, ерөнхий тэргүүн нөөц, ерөнхий удаахь нөөц (ингэснээр удаахь нөөц гишүүн тэргүүн нөөц гишүүн болно).

Шаардлага хангах нөөц гишүүн байхгүй бол Гүйцэтгэх хорооны тогтоосон чиглэлийн дагуу сул орон тоог нөхнө. Гүйцэтгэх хороо нь дараагийн Бүх гишүүдийн хурал тухайн жилд болох тохиолдолд сул орон тоог хэвээр үлдээх шийдвэр гаргаж болно.

Удирдах гишүүний сул орон тоо гарсан тохиолдолд түүнийг Гүйцэтгэх хорооны гишүүдээс нөхөхийн тулд авах арга хэмжээг Гүйцэтгэх хороо шийдвэрлэнэ.

34. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Гүйцэтгэх хорооны санал өгөх эрхгүй гишүүн байна. Тэрээр ажлын албан дахь эрхийнхээ дагуу Захиргааны болон Гүйцэтгэх хороодын үйл ажиллагаанд санал өгөх эрхгүйгээр оролцоно.

35. Гүйцэтгэх хороо нь Холбооны үйл ажиллагаанд түлхэц үзүүлэх зорилгоор Бүх гишүүдийн хурлаар томилсон ажиллагч талуудын гишүүдийг томилно. Ажиллагч

тал бүрт Гүйцэтгэх хорооны дор хаяж нэг гишүүнийг томилж, ажиллагч тал болон Гүйцэтгэх хорооны хоорондын нягт холбоо харилцааг хангаж ажиллана.

36. Ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нар болон санхүүгийн дарга нь Ерөнхий нарийн бичгийн даргын хамтаар Захиргааны хороог бүрдүүлнэ. Захиргааны хороо нь дараахь чиг үүрэгтэй. Үүнд:

а) Ерөнхий нарийн бичгийн даргын үйл ажиллагааг хянах, санхүү, менежментийн болон захиргааны бодлого, гишүүнчлэлийн асуудлыг зохицуулах, тулгамдаж буй асуудал шийдвэрлэх, өргөн цар хүрээтэй бодлогын асуудлыг Гүйцэтгэх хороогоор хэлэлцүүлэхээр бэлтгэнэ.

б) Мөн Гүйцэтгэх хорооны хоёр хурлын хоорондох хугацаанд Бүх гишүүдийн хурал болон Гүйцэтгэх хорооноос тогтоосон бодлогын хүрээнд Холбоог төлөөлнө. Захиргааны хорооны үйл ажиллагааг Гүйцэтгэх хорооны дараагийн хурлаар батална.

37. Ерөнхийлөгч нь Холбооны тэргүүлэх төлөөлөгч байна. Тэрээр Гүйцэтгэх хороо болон Захиргааны хорооны хурлыг удирдан явуулна.

38. Тэргүүн дэд ерөнхийлөгч ба дэд ерөнхийлөгч нар ерөнхийлөгчид ажил үүргээ гүйцэтгэхэд нь туслах бөгөөд түүнийг үүргээ гүйцэтгэх боломжгүй үед эрэмбийн дагуу орлоно.

39. Санхүүгийн дарга нь санхүүгийн бодлогын хэрэгжилт, Холбооны үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянаж, эдгээр асуудлаар Гүйцэтгэх хороо болон Бүх гишүүдийн хуралд тайлагнана.

40. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Холбооны гүйцэтгэх удирдлага байна. Тэрээр Гүйцэтгэх хорооноос томилогдох бөгөөд тус хороонд ажлаа тайлагнана. Ерөнхийлөгч, санхүүгийн дарга болон Ерөнхий нарийн бичгийн дарга нь Холбоог төлөөлөх эрх бүхий этгээдүүд мөн. Захиргааны хорооноос зөвшөөрсөн тохиолдолд тэдний аль ч хоёр нь Холбооны нэрийн өмнөөс гарын үсэг зурж болно.

Бүлэг IX: Тив, бүс нутгийн эвслүүд

41. Холбооны гишүүн эвлэл холбоод тив, бүс нутгийн эвсэл байгуулж болно. Эдгээр эвслийн үйл ажиллагаа тус Үндсэн дүрэм болон Бүх гишүүдийн хурлаас баталсан бодлогод нийцнэ.

42. ОУСХ-ны санхүүгийн тайланг хянах санхүүгийн комисс ажиллана. Санхүүгийн комисс Бүх гишүүдийн хурлаас сонгогдох ба тус хуралд тайлагнана. Санхүүгийн

комисс нь бие даасан гурван аудитороос бүрдэнэ. Тэдний аль нь ч ОУСХ-ны сонгуульт байгууллагад харъяалагдахгүй.

43. ОУСХ-ны жендэрийн чиглэлээрх үйл ажиллагааг зохицуулах, зөвлөх чиг үүрэг бүхий жендэрийн зөвлөл ажиллана. Тус зөвлөл Гүйцэтгэх хорооны эрх мэдэл дор үйл ажиллагааны журам, бүтэц, бодлогоо тодорхойлж, зохих журмын дагуу санхүүжнэ.

Бүлэг X: Санхүүгийн асуудал

44. Бүх гишүүдийн хурлаар гишүүнчлэлийн хураамж тооцох үндэслэлийг тодорхойлж, ОУСХ-ны бүрэн эрхт ба хамтрагч гишүүдийн гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг тогтооно. Гишүүнчлэлийн хураамжийг ОУСХ-ны төв байр байрлаж буй улс орны мөнгөн тэмдэгтээр хийнэ.

45. Холбооны санхүүгийн тайлангийн жил нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно. Гүйцэтгэх хороо нь Холбооны тухайн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулж, төсөв батална.

46. Санхүүгийн тайлант жилийн гишүүнчлэлийн хураамж төлөх хугацаа нь Гүйцэтгэх хороо өөрөөр шийдээгүй бол тухайн жилийн дөрөвдүгээр сарын 30-ны өдөр байна. Тухайн жилд Холбоонд шинээр элссэн гишүүд гишүүнчлэлийн хураамжийг он дуусталх хугацааг хувь тэнцүүлэн тооцож төлнө.

47. Эвлэл холбоодод гишүүнчлэлийн хураамжийн хэмжээ тогтоохдоо тэдний зарласан байнгын гишүүдийн тоог харгалзана. Бүх гишүүдийн хурлаар байнгын гишүүдийн дээд хязгаар тогтооно.

48. Гишүүнчлэлийн хураамж төлөх хугацаанаас 6 сараар хоцроосон аливаа гишүүн эвлэл холбоог Гүйцэтгэх хороонд мэдэгдэнэ. Гүйцэтгэх хороо тухайн эвлэл холбоонд ОУСХ-ны зүгээс үзүүлэх тусламж үйлчилгээг зогсоох шийдвэр гаргаж болно.

49. Гишүүнчлэлийн хураамжаа төлөх хугацаанаас 12 сараар хоцроосон эсвэл Олон улсын үнэмлэх (International Press Cards)-ний нийлүүлэлтийн төлбөрөө төлөөгүй аливаа гишүүн эвлэл холбоо нь Бүх гишүүдийн хуралд санал өгөх эрхгүйгээр оролцоно. Мөн түүнчлэн аливаа ийм гишүүн эвлэл холбоог Бүх гишүүдийн хурлаар эсвэл Гүйцэтгэх хорооны зүгээс Холбооны гишүүнчлэлээс чөлөөлж болно.

50. Гүйцэтгэх хороо онцгой тохиолдолд гишүүн эвлэл холбоодыг гишүүнчлэлийн хураамжаас бүтнээр буюу хэсэгчлэн чөлөөлж болно. Хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх асуудлыг Гүйцэтгэх хороо нарийвчлан шалгана.

51. Бүх гишүүдийн хурлын төлөөлөгчид, Гүйцэтгэх хорооны гишүүд болон ажиллагч талуудын зардлыг Гүйцэтгэх хорооноос өөрөөр шийдвэрлээгүй бол тэдгээрийн гишүүн байгууллагууд гаргана.

52. Санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын шалгалт хийнэ. Аудитын шалгалтын дүгнэлтийг Гүйцэтгэх хорооны гишүүд болон ОУСХ-ны гишүүн байгууллагуудад илгээнэ.

53. Аюулгүй байдлын сан итгэлцэл дээр тулгуурлаж, тусдаа данстай байх бөгөөд өөрийн гэсэн дүрэм журамд захирагдана. Тус санг хөндлөнгийн аудит хянана. Гүйцэтгэх хороо Бүх гишүүдийн хуралд орлого, мөнгөн гүйлгээ, дансны үлдэгдэл зэрэг дэлгэрэнгүй бүртгэл хөтөлсөн тусгай тайланг танилцуулна.

Бүлэг XI: Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, татан буулгах

54. Тус Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Ерөнхий нарийн бичгийн даргад Бүх гишүүдийн хурлын нээлт болох өдрөөс зургаан сарын өмнө бичгээр ирүүлнэ. Ийм төрлийн санал бүр нь эрэлхийлж буй нэмэлт өөрчлөлтийг нарийвчлан тодорхойлж, тухайн нэмэлт өөрчлөлт оруулах шалтгааныг товч тайлбарласан байна. Ерөнхий нарийн бичгийн дарга тухайн өргөдөл болон тайлбар материалыг тэр даруй нийт гишүүн эвлэл холбоодод илгээнэ.

55. Үндсэн дүрэмд санал болгосон нэмэлт өөрчлөлтийг Бүх гишүүдийн хурлын үеэр гуравны хоёроос доошгүйн саналаар батална. Үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлт хийхэд шаардагдах кворум ирц нь Бүх гишүүдийн хурлын нийт төлөөллийн 50-иас доошгүй хувь байна.

56. Холбоог татан буулгах санал нь Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах санал өгөх, шийдвэрлэх зарчмын нэгэн адил явагдана. Гэсэн хэдий ч ийм саналыг Бүх гишүүдийн хурлын нийт төлөөллийн гуравны хоёроос доошгүйн саналаар батална.

57. Бүх гишүүдийн хурлаар Холбоог татан буулгахыг шийдвэрлэсэн тохиолдолд Холбооны бүх өр төлбөрийг барагдуулна. Үлдэж буй мөнгөн хөрөнгийг тухайн үеийн гишүүн эвлэл холбоодод жилийн турш оруулсан хувь нэмрийн хэмжээгээр дүйцүүлэн хуваарилна. Холбооны өр төлбөр барагдуулах мөнгөн хөрөнгө хүрэлцэхгүй бол гишүүн эвлэл холбоод тэнцүү хэмжээгээр хуваан төлнө.

Бүлэг XII: Бусад

58. Уг Үндсэн дүрэмд тусгагдаагүй асуудлыг Бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ. Бүх гишүүдийн хоёр хурлын хоорондох хугацаанд үүссэн асуудлыг Гүйцэтгэх хороо зохицуулна.

59. Бельги улсын 1919 оны аравдугаар сарын 25-ны өдрийн хуулийг баримталсан Тус Үндсэн дүрэмд үл тохирох тусгай нэр томъёо хэрэглэхээс цагт ямагт зайлсхийж, Холбооны шинж чанар, зорилгыг дээд зэргээр дэмжин хангах замаар тайлбарлан, хэрэгжүүлнэ.

60. Бүх гишүүдийн хурлаас Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг дэмжсэн нөхцөлд үр нөлөөг нь нэмэгдүүлэх үүднээс Бельги улсын хуулийн дагуу тухайн өөрчлөлтийг бүртгүүлэх эрхийг Ерөнхийлөгч болон Ерөнхий нарийн бичгийн даргад олгоно. Үндсэн дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийг Эзэн хаанд ёсчлуулахаар (Royal Assent) хүргүүлэх бөгөөд Бельги улсын хуулийн дагуу “Moniteur Belge” албан ёсны сэтгүүлийн хавсралтад нийтлүүлнэ.

Эх сурвалж: <https://www.ifj.org/who/rules-and-policy.html>